



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: БАЯНХОНГОР АЙМГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ

АУДИТЫН КОД: БХА-2026/25/ШТА-НА

“БАЯНХОНГОР АЙМГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ” ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН Ч ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭН ЗӨВ, БОДИТОЙ ТАЙЛАГНААГҮЙ БАЙНА.

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. www.audit.mn

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер М.Алтантуяа

Утас: 70442424 цахим хуудас: altantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Должмаа

Цахим хуудас: dolimaab@audit.gov.mn

Аудитор Г.Энхзул

Цахим хуудас: enkhzulg@audit.gov.mn

Баянхонгор хот. 2026 оны 07 дугаар сарын 08-ны өдөр

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн жагсаалт	3
Дүрслэлийн жагсаалт	3
Хавсралтын жагсаалт	3
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	4
Аудитын зорилго	4
Аудитын хамарсан хүрээ	4
Аудитын арга зүй	4
Аудитын шалгуур үзүүлэлт	4
Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн	5

БҮЛЭГ 1. БАЯНХОНГОР АЙМГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ БАТЛАХДАА ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР, ХҮРЭХ ҮР ДҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХАРИУЦАГЧИЙГ ТОДОРХОЙЛООГҮЙ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА. 7

1.1.Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт уялдуулан боловсруулсан байна.....	7
1.2. “Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг боловсруулахдаа хууль, тогтоомжид заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйгээс төлөвлөлтийн зарчимд нийцээгүй бодлогын баримт бичгийг баталсан байна.....	8

БҮЛЭГ 2. БАЯНХОНГОР АЙМГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ГАРСАН ҮР НӨЛӨӨГ БОДИТОЙ ТООЦООГҮЙ БАЙНА. 10

2.1.“Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгасан арга хэмжээг богино хугацааны хөгжлийн төлөвлөгөөний баримт бичигт тусган хэрэгжүүлсэн байна.	10
2.2. Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгаж хэрэгжүүлсэн арга хэмжээнд зарцуулсан хөрөнгө, үр дүнг бодит гүйцэтгэлд үндэслэн үнэн зөв, бүрэн тайлагнаагүй байна.....	14

ДҮГНЭЛТ.....20

ЗӨВЛӨМЖ 21

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ 22

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
БАХЖТ	Баянхонгор аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө
БАХТЖҮЧ	Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
БОНХОБТХ	Бүс орон нутаг хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НА	Нийцлийн аудит
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТЗУХ	Төрийн захиргаа удирдлагын хэлтэс
ХШҮХ	Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс
ШТА	Шууд тайлагнах аудит

Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	БАХТЖҮЧ-ийн зорилт, арга хэмжээ	6
Хүснэгт 2	ХШҮХ, ЗГХЭГ-ын үнэлгээ	6
Хүснэгт 3	Хууль, тогтоомжийн заалтын хэрэгжүүлснийг харьцуулсан судалгаа	8
Хүснэгт 4	БАХЖТ-нд тусгаагүй арга хэмжээ	11
Хүснэгт 5	Үндсэн чиглэлийн үнэлгээ /хувь/	12
Хүснэгт 6	Нийт зарцуулсан зардлын судалгаа /сая төгрөг/	13
Хүснэгт 7	Баянхонгор аймгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн үнэлгээ	15
Хүснэгт 8	ХШҮХ, ТЗУХ-ын үнэлгээ	17
Хүснэгт 9	Зарим арга хэмжээний суурь, хүрэх түвшин, үр дүнгийн харьцуулалт	18

Дүрслэлийн жагсаалт

Дугаар	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	БАХТЖҮЧ-ийн зорилт, арга хэмжээ	7
Дүрслэл 2	БАХТЖҮЧ, БАХЖТ-ний уялдаа	11
Дүрслэл 3	БАХТЖҮЧ-ийн хэрэгжилтийн үнэлгээ, арга хэмжээгээр	12

Хавсралтын жагсаалт

Дугаар	Агуулга
Хавсралт 1	"Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийг урт хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулсан байдал
Хавсралт 2	"Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн зорилт, арга хэмжээ
Хавсралт 3а	"Баянхонгор аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д тусгасан арга хэмжээг бахжт-д тусгасан байдал
Хавсралт 3б	Баянхонгор аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаагүй арга хэмжээний жагсаалт
Хавсралт 4	"Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн хэрэгжилтэд хшүх, згхэг-аас өгсөн үнэлгээний нэгтгэл
Хавсралт 5	"Баянхонгор аймгийг хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн хэрэгжилтэд өгсөн үнэлгээ
Хавсралт 6	"Баянхонгор аймгийг хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн хэрэгжилтийг байгууллагууд bayankhongor.igovernment.mn цахим системд баталгаажуулсан байдал
Хавсралт 7	"Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн чиглэл"-ийн "үр дүнтэй", "үр дүн гараагүй" арга хэмжээний жагсаалт
Хавсралт 8	Баянхонгор аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн арга хэмжээний зардлын хэмжээ, эх үүсвэрийг bayankhongor.igovernment.mn цахим системд тайлагнасан нэгтгэл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Нийцлийн аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны “Аудитын сэдэв батлах тухай” 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2025 оны А/173, А/179 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө”, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторов 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/01 дүгээр тушаал, газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн хийв.

Аудитын зорилго

Баянхонгор аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хуульд заасан шаардлагын дагуу боловсруулсан эсэх, жил жилийн аймгийн хөгжлийн төлөвлөгөө нь үндсэн чиглэл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн эсэх, хэрэгжилтийг бодитой үнэлж, гарсан үр нөлөөг тооцож зохих арга хэмжээ авсан эсэхийг тодорхойлоход аудитын зорилго чиглэгдсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хууль, журамд заасан шаардлагад нийцүүлж, Засгийн газраас хэрэгжүүлж буй урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан боловсруулсан эсэх;
- Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлж, гүйцэтгэлийг бодитой үнэлэн, үр нөлөөг тооцсон эсэх

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлж байгаа Баянхонгор аймгийн Засаг дарга болон тэдгээрийн харьяа байгууллагууд, холбогдох бусад байгууллагуудыг хамруулж, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагнал, хяналт-шинжилгээ, үнэлгээний баримт материалын хүрээнд аудитыг гүйцэтгэв.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилтод хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, ярилцлага, судалгаа хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан гүйцэтгэж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашигласан. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль,
- Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,
- Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль,
- Монгол Улсын 2021, 2022, 2023, 2024, 2025 оны төсвийн тухай хууль,
- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”,
- Монгол Улсын хөгжлийн 2022, 2023, 2024, 2025 оны төлөвлөгөө,

- Засгийн газрын 2021 оны 119 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нийтлэг журам”
- Засгийн газрын 2022 оны 470 дугаар тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах журам”,
- Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”,
- Засгийн газрын 2025 оны 43 дугаар журам
- Холбогдох бусад хууль, эрх зүйн актууд,
- Баянхонгор аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл,
- Баянхонгор аймаг, сумын ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж,
- Төсөл, арга хэмжээний батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ болон бусад шаардлагууд.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдаж, аудитын менежер М.Алтантуяа үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Должмаа, аудитор Г.Энхзул, зөвлөх Д.Цэцэгмаа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Аудитыг гүйцэтгэхэд гарсан хүндрэл, бэрхшээл:

- “Баянхонгор аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг боловсруулсан шаардлагатай баримт бичиг аймгийн ЗДТГ-ын архивд байхгүй (Аймгийн ЗДТГ-ын 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 2/822 дугаар албан бичиг)
- Аймгийн ЗДТГ-аас аудитад шаардлагатай судалгаа, мэдээллийг удаа дараа шаардуулсан
- Төрийн байгууллагуудын албан хаагчид солигдсоноос 2021-2025 оны мэдээллийг авахад хугацаа их шаардсан болно.

Ерөнхий мэдээлэл:

Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 2/6 дугаар тогтоолоор Баянхонгор аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг баталж, тогтоолын хавсралтаар Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилго, зорилт, арга хэмжээг дараах байдлаар тодорхойлсон байна.

Хүснэгт 1. БАХТЖҮЧ-ийн зорилт, арга хэмжээ

№	Зорилго	Зорилт	Арга хэмжээ
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	1	8
2	Хүний хөгжил	5	31
3	Амьдралын чанар ба дундаж давхарга	4	12
4	Эдийн засаг	4	15
5	Засаглал	1	8
6	Ногоон хөгжил	3	11
7	Амар тайван, аюулгүй нийгэм	3	8
8	Орон нутгийн хөгжил	2	13
ДҮН		23	106

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ЗДТГ-аас ирүүлсэн албан бичиг, таван жилийн үндсэн чиглэлүүд

Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл

8 бодлого, зорилгын хүрээнд нийт 23 зорилт, 106 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан.

Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр 105 арга хэмжээний биелэлтийг үнэлсэн.

Төлөвлөлтийн шаардлага

Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулаагүй

Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт батлаагүй

Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт батлаагүй

Төсөл арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг тодорхойлоогүй

Үндсэн чиглэл боловсруулахад байгууллагаас авсан судалгаа, албан бичиг, тооцооллыг архивлаагүй

Хариуцан хэрэгжүүлэгч байгууллагыг тодорхой тусгаагүй

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ээс “Баянхонгор аймгийг хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийг холбогдох журам, аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар үнэлсэн үнэлгээг ЗГХЭГ-аас дараах байдлаар үнэлсэн байна.

Хүснэгт 2. ХШҮХ, ЗГХЭГ-ын үнэлгээ

Он	Баянхонгор аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ээс өгсөн үнэлгээ	ЗГХЭГ-аас өгсөн дээд шатны үнэлгээ
2021	62.24%	59.52%
2022	87.43%	87.05%
2023	94.3%	88.10%
2024	95.71%	83.90%
2025	93.71%	ЗГХЭГ-ын unelgee.mn сайт дээр хөгжүүлэлт хийж байгаа тул тайланг хүлээн аваагүйгээс дээд шатны үнэлгээ хийгдээгүй байна

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2026 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 11 дүгээр хуралдааны 11/11 дүгээр тогтоолоор “Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийг хэлэлцэж, 94 хувийн буюу “Үр дүн гарсан” гэж дүгнэжээ.

Эх сурвалж: <https://www.new.unelgee.gov.mn/>

БҮЛЭГ 1. БАЯНХОНГОР АЙМГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ БАТЛАХДАА ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР, ХҮРЭХ ҮР ДҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХАРИУЦАГЧИЙГ ТОДОРХОЙЛООГҮЙ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.

1.1. Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт уялдуулан боловсруулсан байна.

1.1. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7¹, 6 дугаар зүйлийн 6.7²-д “Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” нь урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн, дунд хугацааны бодлогын баримт бичиг байхаар заажээ.

1.2. Засгийн газрын 2021 оны 119 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 2.5³-т заасны дагуу “Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг боловсруулж, 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 1а/759 дүгээр албан бичгээр Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн ба журмын 2.6⁴-ын дагуу Үндэсний хөгжлийн газраас ирүүлсэн албан бичгийг аймгийн ЗДТГ-аас олдоогүй гэсэн шалтгаанаар ирүүлээгүй болно. Дүрслэл 1. БАХТЖҮЧ-ийн зорилт, арга хэмжээ

1.3. “Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”, “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д нийцүүлэн боловсруулж, аймгийн ИТХ-ын хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 2/6 дугаар тогтоолоор баталсан байна. (Хавсралт 1)

1.4. “Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг 8 зорилго, 23 зорилтын хүрээнд 106 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. (Хавсралт 2)



Эх сурвалж: Баянхонгор аймгийн ЗДТГ-аас ирүүлсэн БАХТЖҮЧ

1.5. “Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д хэрэгжилтийг тооцох боломжгүй, зорилтыг хангахын тулд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ нь уялдаагүй, нэг зорилтод хэд хэдэн арга хэмжээг багцалж төлөвлөсөн, зарим арга хэмжээг давхардуулан төлөвлөсөн байна.

¹ 4.1.7. Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хөгжлийн зорилтот хөтөлбөрт суурилсан орон нутгийн онцлогийг тусгаасан дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийг,

² 6.7. Дунд хугацааны буюу таван жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл байна.

³ 2.5. Хуулийн 4.1.7, 4.1.9, 4.1.12-т заасан баримт бичгийн төслийг аймаг, нийслэлийн Засаг дарга боловсруулж, холбогдох тооцоо, судалгааны материалын хамт үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлж, ирүүлсэн саналыг төсөлд тусган батлах эрх бүхий байгууллагад өргөн мэдүүлнэ.

⁴ 2.6. Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хуулийн 4.1.7, 4.1.9-д заасан баримт бичгийн төслийг хуулийн 6.7, 6.8-д заасан шаардлагыг хангасан эсэхийг нягталж, санал, дүгнэлтээ аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.

Аудитын илрүүлэлт:

- “Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулах, усны бохирдол хомсдолыг бууруулж ажиллана” гэсэн арга хэмжээг “Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 6.1.6, 8.1.5-д давхардуулан баталсан;
- 4.2.6. Монгол Улсад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” /SECiM/ төслийг хэрэгжүүлэх -Уг төсөл нь Монгол улсад 2016 оны 02 дугаар сараас 2021 оны 01 дүгээр сар хүртэл 1 үе шаттай, 5 аймгийг хамруулан хэрэгжсэн төсөл ба уг төсөлд хамрагдсан аймагт Баянхонгор аймгийг хамруулаагүй байхад хамруулахаар төлөвлөснөөс хэрэгжих боломжгүй болсон байхад хэрэгжүүлэхээр төлөвлөсөн;
- 2.3.6 Угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээж, өрх бүр угийн бичиг хөтөлж, хүүхэд, залуучуудад түгээн дэлгэрүүлсэн байна;
- 6.1.9. Хүлэмжийн хийн ялгарлыг 10 хувиар бууруулна.
- 8.1.6. Өлзийт, Баян-Овоо, Эрдэнэцогт сумдыг дагуул сум болгон хөгжүүлж, хүн амын шилжилт хөдөлгөөнийг сааруулна

Эдгээр арга хэмжээнээс 6.1.9 дэх арга хэмжээнээс бусад арга хэмжээг “Баянхонгор аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгаагүй байна.

Шийдвэрлэлт: “Баянхонгор аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгасан арга хэмжээний зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлтийг дахин нягтлан сайжруулах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

1.6. “Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг батлахдаа бодлогын баримт бичигт тусгасан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг тусгаагүй нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6⁵, 5.2.6⁶, 6 дугаар зүйлийн 6.7.2.6⁷ дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.

1.2. “Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг боловсруулахдаа хууль, тогтоомжид заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйгээс төлөвлөлтийн зарчимд нийцээгүй бодлогын баримт бичгийг баталсан байна.

1.7. “Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Засгийн газрын 2021 оны 119 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын дараах шаардлагыг бүрэн хангаагүй байна.

Харин Баянхонгор аймгийн ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 10 дугаар хуралдааны 10/62 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар “Баянхонгор аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг дээрх хууль, тогтоомжийн дагуу баталсан нь цаашдын хөгжлийн бодлого, төлөвлөлтийг хуульд нийцүүлэх арга хэмжээ авч ажилласныг харуулж байна.

Хүснэгт 3. Хууль, тогтоомжийн заалтын хэрэгжүүлснийг харьцуулсан судалгаа

Үзүүлэлт	Баримт бичигт тусгасан байдал 2021-2025	Баримт бичигт тусгасан байдал 2026-2030
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль		
5.2.3. “нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх зарчим” гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, мэдээлэл, аргачлал нь нэгдмэл, уялдаатай байж, бодлогыг төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, хяналт-шинжилгээ,	“Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн, зорилтот түвшингүй баталснаас хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд нэгдмэл байдал алдагдсан	Баянхонгор аймгийн ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 10/62 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар “Баянхонгор аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн үр дүнг, 3 дугаар хавсралтаар үр дүнгийн хяналт-

⁵ 5.1.6. Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд дараах зарчмыг баримтална: нөөц, эх үүсвэрт үндэслэсэн байх;

⁶ 5.2.6. “нөөц, эх үүсвэрт үндэслэсэн байх зарчим” гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, батлах, төлөвлөх, хэрэгжүүлэхдээ байгалийн баялаг, түүхий эд, хөрөнгө санхүү, техник технологи, шинжлэх ухаан, инновац, ур чадвартай ажиллах хүчин болон шаардлагатай бусад нөөцийг урьдчилан тооцоолсон төсөв, төсөөллийн дагуу тодорхойлсон хязгаарлалтын хүрээнд тусгахыг;

⁷ 6.7.2.6. Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг тооцсон төсөл, арга хэмжээг тусгасан хөтөлбөрийг хавсаргах;

үнэлгээ хийх үйл ажиллагааны нэгдмэл байдлыг		шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтийг баталсан байна.
5.2.6."нөөц, эх үүсвэрт үндэслэсэн байх зарчим" гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, батлах, төлөвлөх, хэрэгжүүлэхдээ байгалийн баялаг, түүхий эд, хөрөнгө санхүү, техник технологи, шинжлэх ухаан, инновац, ур чадвартай ажиллах хүчин болон шаардлагатай бусад нөөцийг урьдчилан тооцоолсон төсөв, төсөөллийн дагуу тодорхойлсон хязгаарлалтын хүрээнд тусгахыг	"Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд хэчнээн хэмжээний санхүүгийн нөөц гарахыг урьдчилсан тооцоолсон төсөв байхгүй.	"Баянхонгор аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийг боловсруулахад зөвхөн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний судалгааг нэгтгэж, тогтоолын 4 дүгээр хавсралтаар "Хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийг баталж, хөрөнгө оруулалтын төсөвт өртөг, санхүүжилтийн эх үүсвэрийг тусгасан, бусад эх үүсвэрийг тусгаагүй байна.
5.2.8."судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх зарчим" гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн зорилго, зорилт, хүрэх үр дүнг тодорхойлохдоо нөөцийн хязгаарлалт болон эрсдэлийг харгалзан үзэж, тогтоосон хугацаанд биелүүлэх боломжтой, бодит, хэмжигдэхүйц зорилго, зорилт дэвшүүлэхийг	"Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийг боловсруулахдаа ямар судалгаа, шинжилгээ хийсэн талаарх мэдээллийг аудитын багт ирүүлээгүй, зорилго, зорилтыг тодорхойлохдоо хэмжигдэхүйц байдлаар тодорхойлоогүй.	Зарим байгууллагаас үр дүн, нөхцөл байдал, шалгуур үзүүлэлтийг гаргасан албан бичгийг ирүүлсэн, аймгийн Засаг даргын харьяа 40 байгууллагын удирдлага, албан хаагчдыг оролцуулж, хэлэлцүүлгийг зохион байгуулсан байна.
5.2.9."зорилго, зорилт хэмжигдэхүйц байх зарчим" гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн зорилтын гүйцэтгэлийг бодлого, төлөвлөлтийн үйл явцад тодорхой тоон болон чанарын үзүүлэлт бүхий шалгуур үзүүлэлтийг ашиглан үнэлж, хэмжих боломжтой байхыг	"Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийг хэрэгжүүлэхээс өмнө тоон үзүүлэлтүүдийг тодорхойлоогүйгээс цаашид ямар үр дүнд хүрснийг хэмжих боломжгүй.	Баянхонгор аймгийн ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 10/62 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтийг баталсан байна.
5.2.10."шалгуур үзүүлэлт нь зорилготой нийцэж байх зарчим" гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн гүйцэтгэлийг тоон болон чанарын үзүүлэлтээр хянах боломжтой байхыг	"Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийг шалгуур үзүүлэлтийг тодорхой заагаагүйгээс гүйцэтгэлийг журмын дагуу үнэлэх боломжгүй.	Баянхонгор аймгийн ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 10/62 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар "Баянхонгор аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн үр дүнг, 3 дугаар хавсралтаар үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтийг баталсан ба аудитад "Баянхонгор аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" хамаарахгүй тул шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тулгаагүй.
5.2.11."төлөвлөлт нь үр дүнд чиглэсэн байх зарчим" гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг хэрэгжүүлснээр бий болох үр дүнг тодорхойлж, түүнд чиглэсэн зорилго, зорилт, үйл ажиллагааг тодорхой зохион байгуулалт, дэс дарааллын дагуу төлөвлөхийг	"Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д тусгасан арга хэмжээг хэрэгжүүлснээр бий болсон үр дүнг анх төлөвлөсөнтэй харьцуулах боломжгүй	Баянхонгор аймгийн ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 10/62 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар "Баянхонгор аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн үр дүнг баталсан байна.
5.2.12."төлөвлөлтийн дээрээс доош, доороос дээш чиглэх тэнцвэрийг хангах зарчим" гэж "дээрээс доош" төлөвлөх буюу нэгдсэн зорилго, зорилтыг дэвшүүлж салбар болон бүс нутгуудад хэрэгжүүлэх, "доороос дээш" төлөвлөх буюу төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрүүдийн саналыг нэгтгэн, нэгдмэл зорилго, зорилтыг тодорхойлж төлөвлөхийг	"Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийг боловсруулахад байгууллагуудаас ирүүлсэн санал, баримт материалыг Баянхонгор аймгийн ЗДТГ-аас ирүүлээгүйгээс "доороос дээш" төлөвлөлтийн зарчмыг баримталсан эсэхэд дүгнэлт өгөх боломжгүй байна.	"Баянхонгор аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 4 дүгээр хавсралтаар "Хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-т гадаадын зээл, олон улсын болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг тусгасан боловч эдгээрээс ирүүлсэн саналыг анхан шатны баримтад хавсаргаагүй.
5.2.13."бүх талын оролцоог хангасан байх зарчим" гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, иргэд, сонирхлын бүлгийн оролцоог ханган боловсруулсан байхыг	"Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийг боловсруулахдаа бүх талын оролцоог хангасан талаарх баримт материалыг аудитын багт ирүүлээгүй	"Баянхонгор аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийг боловсруулахад зөвхөн төрийн байгууллагын албан хаагчдыг оролцуулж, бүх талын оролцоог хангаж ажиллаагүй байна.

11.2. ...шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, хэрэгжүүлэх арга зам, үе шат, хүрэх үр дүн, бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгэм, байгаль орчинд бий болох үр нөлөө, эрсдэл, санхүүгийн эх үүсвэр, хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө, хариуцах байгууллагыг тусгана.	"Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д эдгээр шаардлагыг тусгаагүй	Баянхонгор аймгийн ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 10/62 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар "Баянхонгор аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийг хэрэгжүүлснээр гарах үр нөлөөг тодорхойлсон байна.
11.3. ...олон талын оролцоог хангасан байх ба эцэслэгдсэн төслийг олон нийтээр хэлэлцүүлнэ.	"Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн эцэслэсэн төслийг олон нийтээр хэлэлцүүлээгүй	"Баянхонгор аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийг олон нийтээр хэлэлцүүлээгүй байна.
Засгийн газрын 2021 оны 119 дүгээр тогтоолоор баталсан "Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нийтлэг журам"		
2.8.Хуульд заасан эрх бүхий байгууллага хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг урьдчилан төлөвлөсөн байна.	"Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д шаардагдах хөрөнгө, санхүүжилтийн эх үүсвэрийг тусгаагүй	"Баянхонгор аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д хөрөнгө оруулалтын шинж чанартай төсөл арга хэмжээг тусгасан байна.
3.2.Эрх бүхий байгууллага хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулахдаа олон талын оролцоог хангаж, удирдамжаар хангана	Ажлын хэсэг байгуулсан шийдвэрийг аудитын багт ирүүлээгүй	Баянхонгор аймгийн Засаг даргын 2025.08.28-ны өдрийн А/488 дугаар захирамжаар аймгийн ЗДТГ-ын даргаар ахлуулж, хэлтсийн дарга, ахлах мэргэжилтнүүдийг оролцуулсан "Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах ажлын хэсэг"-ийг 14 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ.
3.6.Бодлогын баримт бичгийн зорилго, зорилт, арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшнийг тодорхойлно.	"Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д тусгасан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшнийг тодорхойлоогүй	"Баянхонгор аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшнийг тодорхойлсон.
3.7.Бодлогын баримт бичгийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, шаардагдах хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлно.	"Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалт, санхүүжилтийг эх үүсвэрийг урьдчилан тооцоолоогүй	"Баянхонгор аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийг боловсруулахад зөвхөн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний судалгааг нэгтгэж, тогтоолын 4 дүгээр хавсралтаар "Хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийг баталсан байна.

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ЗДТГ-аас ирүүлсэн албан бичиг, таван жилийн үндсэн чиглэлүүд

"Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийг боловсруулах үйл явцад 2020 онд оролцсон байгууллагууд, албан хаагчдын ажлын уялдаа холбоо хангалтгүй, хариуцлагагүй байдал нь төлөвлөлтийн чанарт сөргөөр нөлөөлсөн байна.

Иймд "Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" дунд хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулахдаа холбогдох хууль, тогтоомжийг баримталж, олон талын оролцоог хангаж үндсэн чиглэлийг боловсруулж, эцэслэгдсэн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх, шаардагдах хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрэн тусгахыг аймгийн Засаг даргад зөвлөж, аймгийн ИТХ-д толилуулав.

БҮЛЭГ 2. БАЯНХОНГОР АЙМГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ГАРСАН ҮР НӨЛӨӨГ БОДИТОЙ ТООЦООГҮЙ БАЙНА.

2.1."Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д тусгасан арга хэмжээг богино хугацааны хөгжлийн төлөвлөгөөний баримт бичигт тусган хэрэгжүүлсэн байна.

2.1. Дунд хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичгийг хэрэгжүүлэх талаар Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- ✓ Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.14-т "Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө" гэж Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан, тухайн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тусгасан төсөл, арга хэмжээ бүхий төлөвлөлтийн баримт бичгийг;
- ✓ Хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.4-т "Орон нутгийн төсөв нь Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх"

Эдгээр заалтын дагуу "Баянхонгор аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д тусгасан арга хэмжээг "Баянхонгор аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө"-д дараах байдлаар тусгажээ.

Дүрслэл 2. БАХТЖҮЧ, БАХЖТ-ний уялдаа



Эх сурвалж: Аудиторын тооцоолол

2.2. Баянхонгор аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан арга хэмжээнүүдийг 2021-2025 оны Баянхонгор аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгасан эсэхийг авч үзэхэд дараах байдалтай байна. (Хавсралт 3а)

Хүснэгт 4. БАХЖТ-нд тусгаагүй арга хэмжээ

Зорилго	Арга хэмжээний тоо	Уялдаагүй	
		Тоо	Хувь
Зорилго 1	8	3	37.5%
Зорилго 2	31	4	12.9%
Зорилго 3	12	1	8.3%
Зорилго 4	15	0	0.0%
Зорилго 5	8	1	12.5%
Зорилго 6	11	1	9.1%
Зорилго 7	8	0	0.0%
Зорилго 8	13	3	23.1%
Нийт	106	13	12.3%

1.1.5 Иргэн бүрийн ном унших дадал, хэвшлийг нэмэгдүүлж, сумдын номын сангийн үйлчилгээг өргөжүүлж, үйл ажиллагааг сайжруулна.

1.1.6 Аймгийн түүхийн музейн барилгыг ашиглалтад оруулж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн биет болон биет бус өвийн мэдээллийн сангийн баяжилтыг сайжруулна.

1.2.2 Хүүхэд, залуучуудын Монгол хэл бичгийн чадварыг дээшлүүлж, "Цахим соёл" арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.3.1 Гэр бүлийн боловсролыг бүх насны хүмүүст амьдралын мөчлөг, насны онцлогт тохирсон байдлаар олгоно.

2.4.1 Эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулийн хамтарсан "Судалгааны баг" байгуулж, судалгааны ажлын нийгэм, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлнэ.

2.4.2 Эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжиж, шинэ мэдлэг, патентыг үйлдвэрлэлд нэвтрүүлнэ.

2.5.2 Ахмад настанд зориулсан "Хөгжлийн төв"-ийг барьж, сум суурин газарт ахмадын нийгмийн суурь үйлчилгээг тэгш хүргэнэ.

3.2.1 Төр, хувийн хэвшлийн оролцоотой "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

5.1.3 Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудаар гүйцэтгүүлж гурван талт түншлэлийг оновчтой, үр дүнтэй нэвтрүүлнэ.

6.1.9 Хүлэмжийн хийн ялгарлыг 10 хувиар бууруулна.

8.1.2 Аймгийн Нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж, нислэгийн тоог нэмэгдүүлэх, нисэх буудлын үйл ажиллагааг олон улсын стандартад хүргэнэ.

8.1.3 Инновац, дэвшилтэт техник технологи, дижитал шилжилтийг АТҮТөөд нэвтрүүлж ухаалаг тээврийн нэгдсэн тогтолцоог хангуулж ажиллана.

8.1.7 Олон улсын стандартад нийцсэн унадаг дугуйн зам барьж, иргэдэд ая тухтай зорчих боломжийг нэмэгдүүлнэ.

Эх сурвалж: Аудиторын тооцоолол


Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийт 13 арга хэмжээ буюу 12.3 хувь нь огт тусгаагүй байгаа ба энэ нь нэг талаар төлөвлөлт оновчтой бус нөгөө талаар үндсэн чиглэлд тусгасан арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжихгүй байх нөхцөлийг үүсгэсэн байна. (Хавсралт 3б)

Шийдвэрлэлт: “Баянхонгор аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээг богино хугацааны бодлогын баримт бичигт тусган хэрэгжих нөхцөл боломжийг бүрдүүлэх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

“Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгасан арга хэмжээний хэрэгжилтэд 2021-2024 онд 1 арга хэмжээний үнэлгээг орхигдуулж 105 арга хэмжээг үнэлсэн ба 2021-2025 онд аймгийн ХШҮХ-ээс өгсөн үнэлгээг дүрслэлээр харуулбал: (Хавсралт 5)

Дүрслэл 3. БАХТЖҮЧ-ийн хэрэгжилтийн үнэлгээ, арга хэмжээгээр



Эх сурвалж: Аудиторын тооцоолол

2.3. “Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тодорхойлсон зорилго, зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний дундаж үнэлгээг хэрэгжүүлэгч байгууллагуудаас ирүүлснийг ТЗҮХ нэгтгэж тайлагнахдаа хувиар тайлагнаагүйгээс ХШҮХ-ийн үнэлгээтэй харьцуулж, дүн шинжилгээ хийх боломжгүй байна.

Хүснэгт 5. Үндсэн чиглэлийн үнэлгээ /хувь/

№	Зорилго, зорилт	Арга хэмжээний тоо	ТЗҮХ-ээс өгсөн үнэлгээ	ХШҮХ-ийн үнэлгээ	Аудитаар үнэлсэн үнэлгээ
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	8	Үнэлгээг хувиар нэгтгэн тайлагнаагүй	93.4	81.1
2	Хүний хөгжил	31		97.0	88.4
3	Амьдралын чанар ба дундаж давхарга	12		92.5	87.3
4	Эдийн засаг	14		90.8	81.4
5	Засаглал	8		94.5	86.4
6	Ногоон хөгжил	11		99.4	90.1
7	Амар тайван, аюулгүй нийгэм	8		94.4	85.1
8	Орон нутгийн хөгжил	13		93.8	87.8

Эх сурвалж: Аймгийн ЗДТГ-ын ХШҮХ, аудитын үнэлгээ

Дээрх үзүүлэлтээс харахад “Амьдралын чанар ба дундаж давхарга”, “Эдийн засаг”, зорилтын хүрээнд тодорхойлсон арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн арга хэмжээний нэгдсэн тайланг <https://bayankhongor.igovernment.mn/> цахим системд Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс нэгтгэн оруулахдаа үнэлгээгүй тайлагнадаг тул хэрэгжүүлэгч байгууллагын үнэлгээг тооцох боломжгүй байна.
- Холбогдох байгууллагуудын “Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийг үнэлсэн үнэлгээнээс харахад үнэлгээг бодит гүйцэтгэл, нотлох баримтад суурилсан, цогц байдлаар хийгээгүй байна.

Шийдвэрлэлт: Хэрэгжүүлэгч байгууллагуудаас ирүүлсэн тайлан, мэдээнд дүн шинжилгээ хийж, эх сурвалжийн найдвартай, нотлогдохуйц, бодитой байдлыг харгалзаж, үнэлгээг хяналт-шинжилгээ, үнэлгээний системд оруулж байх зөвлөмжийг ТЗҮХ-т хүргүүлэв.

2.4. Баянхонгор аймгийн ЗДТГ-аас “Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг хэрэгжүүлэхэд гарсан нийт зардлыг тооцсон судалгаа байхгүй ба bayankhongor.igovernment.mn цахим систем-д 2021 онд 27,746.0 сая, 2023 онд 669.4 сая, 2025 онд 73.7 сая төгрөгийг зарцуулснаар тайлагнасан нь албан хаагчдын хариуцлага, дотоод хяналт сул байгаатай холбоотой байна. (Хавсралт 8)

2.5. Аудитаар үндсэн чиглэлийг хэрэгжүүлэгч зарим байгууллагыг түүвэрт хамруулж, ТЗУХ, БОНХОБТХ-ээс 2021-2025 онд зарцуулсан зардлын дүнг гаргуулахад “Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг хэрэгжүүлэхэд 2021-2025 онд хөрөнгө оруулалтын зардалд 460,918.7 сая, арга хэмжээний зардалд 336,107.1 сая, нийт 797,025.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 6. Нийт зарцуулсан зардлын судалгаа /сая төгрөг/

Бодлого, зорилгын нэр	ТАХ-ний тоо	Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн дүн	Хөрөнгө оруулалтаас бусад арга хэмжээний санхүүжилтийн дүн	Нийт санхүүжилт
Нэг. Үндэсний нэгдмэл үнэт зүйл	8	1,479.0	177,430.1	178,909.1
Хоёр. Хүний хөгжил	31	187,592.0	132,434.3	320,026.3
Гурав. Амьдралын чанар ба дундаж давхарга	12	20,589.8	17,629.1	38,218.9
Дөрөв. Эдийн засаг	15	97,597.1	7,933.2	105,530.3
Тав. Засаглал	8	1,734.0	325.5	2,059.5
Зургаа. Ногоон хөгжил	11	2,823.4	129.0	2,952.4
Долоо. Амар тайван, аюулгүй нийгэм	8	2,860.9	79.9	2,940.8
Найм. Орон нутгийн хөгжил	13	146,242.5	146.0	146,388.5
Нийт	106	460,918.7	336,107.1	797,025.8
Үүнээс санхүүжилтийн эх үүсвэрээр				
Орон нутгийн хөгжлийн сан		7,608.6	102.5	7,711.1
Орон нутгийн төсөв /Замын сан, их засвар, Хөгжлийн төлөвлөгөө, БХНСАХЗ/		80,253.7	7,695.4	87,949.1
Улсын төсөв		348,613.9	185,709.1	534,323.0
ХЭДС		0	17,567.8	17,567.8
ЭМДСан		0	121,800.0	121,800.0
Хандив		1,678.4	0	1,678.4
ЖДҮ Дэмжих сан		0	2,734.4	2,734.4
Бусад		22,764.2	497.9	23,262.1
Нийт санхүүжилтэд улсын төсвийн эзлэх хувь		75.6	55.3	67.0

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

Аудитаар хийсэн хөрөнгө оруулалтын судалгаагаар 2021-2025 онд нийт 481,789.6 сая төгрөгийн зардлыг зарцуулахаар төлөвлөж, 460,917.8 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан байна.

Хөрөнгө оруулалтын арга хэмжээний зардлын гүйцэтгэлийг үндсэн чиглэлд тусгасан арга хэмжээний зорилтоор авч үзэхэд зардлын дийлэнх хувийг Хүний хөгжил, орон нутгийн хөгжлийн зорилтод дэвшүүлсэн арга хэмжээний зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн ИТХ-д ТЗУХ-ээс үндсэн чиглэлийг хэлэлцүүлэхэд 2021-2025 онд хөрөнгө оруулалтын арга хэмжээнд нийт 354,640.0 сая төгрөгийг зарцуулснаар тайлагнасан байхад аудитаар хийсэн судалгаагаар 460,917.7 сая төгрөгийн зарцуулсан байгаа нь зардлын дүнг 106,277.7 сая төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Гүйцэтгэлийг тайлагнагч байгууллагууд арга хэмжээг хэрэгжүүлэхэд гарсан зардал, ямар эх үүсвэрээс санхүүжсэн талаар тайлагнадаггүй, тайлагнасан байгууллага нь бүрэн тайлагнаагүй;
- ТЗУХ арга хэмжээний зардлын дүнг нотлох баримтад үндэслэн нэгтгэж тайлагнаагүйгээс үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд гарсан зардлын дүнг хэлэлцдэггүй, түүнд ХШҮХ-ээс хяналт тавьдаггүй;
- Хөрөнгө оруулалтын арга хэмжээний зардалд урсгал зардлыг нэгтгэж тайлагнасан;
- Байгууллагуудаас ирүүлсэн зардлыг ТЗУХ орхигдуулж тайлагнаснаас зардлын дүн дутуу тусгагдсан;
- Японы “Өвсний үндэс” хөтөлбөр, “Ger and Nature” (гэр ба байгаль) аялал жуулчлалын төсөл, “Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь /Ensure/” төсөл, “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл”, “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох

стратегийн төлөвлөлтийг боловсронгуй болгох, орон нутгийн иргэдийн байгаль орчин болон байгалийн нөөцийн салбарт дасан зохицох чадавхийг бэхжүүлэх” төсөл, BEST хөтөлбөр, “Тогтвортой ноолуур” төсөл, Эх хүүхдийн эрүүл мэндэд агаарын бохирдлын үзүүлэх нөлөөллийг бууруулах төсөл, Тэгш хүртээмжтэй цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь төсөл зэрэг төслүүдээс 2021-2025 онд нийт 9,656.3 сая төгрөгийн хандив тусламж үзүүлсэн байхад тайлагнаагүй орхигдуулсан;

- Улсын төсвөөс болон хандив тусламжаар хэрэгжүүлсэн арга хэмжээний зардлыг нэгтгэдэггүй, зөвхөн аймгийн ИТХ-ын тогтоолын дагуу олгосон зардлыг тайлагнасан, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллагуудын мэдээлэл өөр хоорондоо зөрүүтэй байгаа нь төрийн байгууллагын албан хаагчид харилцан уялдаагүй, хуульд заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй гэж дүгнэхээр байна.

2.6. “Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгасан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс дараах төсөл арга хэмжээний эх үүсвэрийг шийдвэрлээгүйгээс хэрэгжээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

- 1.1.6 Аймгийн түүхийн музейн барилгыг ашиглалтад оруулж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн биет болон биет бус өвийн мэдээллийн сангийн баяжилтыг сайжруулна
- 2.5.2. Ахмад настанд зориулсан “Хөгжлийн төв”-ийг барьж, сум суурин газарт ахмадын нийгмийн суурь үйлчилгээг тэгш хүргэнэ

Шийдвэрлэлт: Дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгасан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэж, төсөл арга хэмжээг хэрэгжүүлж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

2.2. Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгаж хэрэгжүүлсэн арга хэмжээнд зарцуулсан хөрөнгө, үр дүнг бодит гүйцэтгэлд үндэслэн үнэн зөв, бүрэн тайлагнаагүй байна.

2.7. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 10-т Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, захиргааны байгууллагын үйл ажиллагааг үнэлэх, тайлан илгээх, хүлээн авах, мэдээллийн урсгалыг удирдах, хянах, хадгалах, ашиглах, түгээхэд Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санг ашиглан мэдээллийг тогтоосон хугацаанд байршуулахаар заасан байна.

2.8. Баянхонгор аймгийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/540 дүгээр захирамжаар Баянхонгор аймгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаанд онлайн систем нэвтрүүлж, цахим санд шилжүүлснээр бодлогын баримт бичгүүдийг цахимаар үнэлж эхэлжээ.

2.9. “Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг <https://bayankhongor.igovernment.mn> цахим системд тайлагнах 29 байгууллага, аймгийн ЗДТГ-ын 6 нэгжээс зарим байгууллага хугацаандаа тайлан ирүүлээгүй, хугацаа хоцроосон зөрчилтэй байна. (Хавсралт 6)

Аудитын илрүүлэлт:

- 2021 онд 15, 2021-2022 онд тус бүр 1, 2024-2025 онд тус бүр 3 байгууллага хугацаа хоцорч тайлагнасан;
- 2021 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Соёл урлагийн газар, 2022 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, 2023 онд Нийгмийн даатгалын газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, “Жаргалтай амьдрал” сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний төв, 2024 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, 2025 онд аймгийн Байгаль орчны газар, “Жаргалтай амьдрал” сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний төв зэрэг байгууллагууд арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнаагүй;
- Аймгийн ХШҮХ-ээс 2024 онд хугацаа хоцроож тайлан илгээсэн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн үнэлгээг 2 хувиар бууруулаагүй,
- Аймгийн ХШҮХ-ээс тайлан ирүүлээгүй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үнэлгээг 5 хувиар бууруулахаас 2 хувиар бууруулсан байна.

Дээрх нь А/286 дугаар захирамжаар баталсан журмын 9.6.1⁸, Баянхонгор аймгийн Засаг даргын 2023 оны А/05 дугаар захирамжаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, нутгийн захиргааны болон орон нутгийн өмчит байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 5.4.7⁹, 5.4.8¹⁰ дахь заалтыг зөрчсөн байна.


Иймд хэрэгжилтийг тайлагнагч байгууллагууд бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг заасан хугацаанд, үнэн зөв, бодит гүйцэтгэлд үндэслэн цахим системд мэдээлэх, мэдээлээгүй тохиолдолд аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар баталсан журмын дагуу хариуцлага тооцож байхыг аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ын даргад зөвлөв.

2.10. Хэрэгжүүлэгч байгууллагуудаас үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, үр нөлөөг <https://bayankhongor.igovernment.mn> цахим системд оруулсныг Баянхонгор аймгийн ЗДТГ-ын ТУЗХ нэгтгэн дүгнэснийг Засгийн газрын 2020 оны 206, 2021 оны 374, 2025 оны 43, аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар баталсан журамд заасан аргачлалаар аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ээс жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна. (Хавсралт 4,5)

2.11. “Баянхонгор аймгийн хөгжлийн таван жилийн үндсэн чиглэл”-д тусгасан арга хэмжээний гүйцэтгэлийн үр дүнг хэрэгжилтийг хувиар үнэлэхэд үндсэн чиглэлийг анх боловсруулахдаа шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, суурь түвшнийг тодорхойлоогүйгээс Засгийн газрын 2020 оны 206, 2025 оны 43 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар баталсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журмын 6.2.1, 6.1, 5.3.1 заалтын дагуу үнэлэх боломжгүй байна. Иймд журмын 6.2.2¹¹, 6.2¹²-т заасны дагуу арга хэмжээг үнэлсэн байна.

2.12. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журмын 7.7.1¹³-т заасны дагуу аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ээс “Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийг жил бүр үнэлж, эрх бүхий дээд байгууллагад 2022-2023 онд албан бичгээр цаасан хэлбэрээр, 2024-2025 онд unelgee.gov.mn цахим системээр цахимаар хэлбэрээр тайлагнасан байна.

СЭ ТӨРИЙН МЭДЭЭЛЛИЙН СҮЛЖЭЭ :: МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР



2.13. “Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтэд аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ээс өгсөн үнэлгээг ЗГХЭГ-аас 2021 онд 2.7 оноогоор, 2022 онд 0.4 оноогоор, 2023 онд 6.2 оноогоор, 2024 онд 11.8 оноогоор бууруулж үнэлсэн байна. (Хавсралт 4)

Хүснэгт 7. Баянхонгор аймгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн үнэлгээ

Он	Баянхонгор аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ээс өгсөн үнэлгээ	ЗГХЭГ-аас өгсөн дээд шатны үнэлгээ
2021	62.24%	59.52%
2022	87.43%	87.05%

⁸ 9.6.1. Нутгийн захиргааны болон орон нутгийн өмчийн байгууллага хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжийн болон тухайн асуудал хариуцсан ажилтан цахим санд нэвтэрч, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авч, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг энэхүү журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд оруулах

⁹ 5.4.7. Баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнахдаа хугацаа хоцроосон бол тайлан тус бүрийн тоогоор тухай жилийн үйл ажиллагааны болон явцын үнэлгээг 2 хувиар бууруулна.

¹⁰ 5.4.8. Баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнаагүй бол ирүүлээгүй тайлан тус бүрийн тоогоор тухайн жилийн үйл ажиллагааны болон явцын үнэлгээг 5 хувиар бууруулна

¹¹ 6.2.2. Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хүрсэн түвшнийг тоо болон чанараар илэрхийлэх боломжгүй үед хэрэгжилтийн хувийг тодорхойлоход дараах аргачлалаар тооцно:

¹² 6.2. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үр дүнг гарцын нөлөөгөөр бий болсон, эсхүл бий болох эерэг болон сөрөг өөрчлөлтөөр тодорхойлно.

¹³ 7.7.1. нутгийн захиргааны байгууллага Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ. Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжилтийн тайланг нэгтгэж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тайланг хянан үзэж Засгийн газрын хуралдаанд танилцуулна.

Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл

2023	94.3%	88.10%
2024	95.71%	83.90%
2025	93.71%	ЗГХЭГ-ын unelgee.mn сайт дээр хөгжүүлэлт хийж байгаа тул тайланг хүлээн аваагүйгээс дээд шатны үнэлгээ хийгдээгүй байна

Эх сурвалж: Засгийн газрын хяналт, шинжилгээ үнэлгээний цахим систем, Баянхонгор аймгийн ХШҮХ-ээс ирүүлсэн судалгаа

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ээс өгсөн хяналт-шинжилгээ, үнэлгээг аудитаар аудитын түүвэрт хамрагдсан байгууллагуудаас ирүүлсэн баримт, материалд үндэслэн үнэлгээ өгсөн бөгөөд тус нөхцөл байдалтай холбоотойгоор үнэлгээ хийсэн байгууллагуудын “Үнэлгээ” болон ТАБ-ын “Үнэлгээ”-ний хооронд зөрүү үүссэн болно.

2.14. Баянхонгор аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ээс 2026 оны 03 дугаар сард өгсөн хяналт-шинжилгээ, үнэлгээг аудитаар аудитын түүвэрт хамрагдсан байгууллагуудаас ирүүлсэн баримт, материалд үндэслэсэн үнэлэхэд “Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг 86.0 хувьтай хэрэгжүүлж “Үр дүн гарсан” гэж үнэлэв.

2025 оны үнэлгээ	Unelgee.gov.mn цахим системд “Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийг тайлагнах систем баталгаажуулах эрх нээгээгүйгээс хэрэгжилтийг тайлагнаагүй, ЗГХЭГ-аас үнэлгээ хийгдээгүй байна.
------------------	--

“Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийг тайлагнасан газруудаас аудитын түүвэрт хамруулж, 2021-2025 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, зардлын судалгааг гаргуулж, аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ээс гаргасан судалгаатай тулгаж, бодлогын баримт бичгийг тулгахад дараах зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

- 4.2.11 дахь “Монгол Улсын гадаад бодлогод нийцүүлэн Холбооны гишүүн орнуудтай харилцаа холбоогоо улам өргөжүүлэх, хамтран төсөл хэрэгжүүлэх, худалдаа эдийн засгийн харилцааг шинэ түвшинд хүргэнэ” арга хэмжээний хэрэгжилтийг үнэлж, системд тайлагнаагүй;
- “Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийг тайлагнах байгууллагуудаас арга хэмжээний хэрэгжилтийг хувиар үнэлж ирүүлснийг аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ээс нэгтгэн гаргахдаа хувиар үнэлдээгүй;
- ХШҮХ-ийн системд арга хэмжээний зардалд төлөвлөсөн болон зарцуулсан хөрөнгийн дүн, эх үүсвэрийг бүрэн, үнэн зөв тайлагнадаггүй;
- 2021 онд 33, 2023 онд 8, 2025 онд 2 арга хэмжээний төсөв, зарцуулсан хөрөнгийн хэмжээг цахим системд мэдээлсэн нь хангалтгүй; (Хавсралт 8)
- Зарцуулсан хөрөнгийн мөнгөн дүн төгрөгөөр, сая төгрөгөөр гэх мэтээр өөр өөр дүнгээр илэрхийлсэн; (Хавсралт 8)
- Хэрэгжүүлэгч байгууллага хэрэгжилтийг өссөн дүнгээр, хэрэгжсэн хугацааны дүнгээр тайлагнадаггүй, нотлох баримтыг бүрэн хавсаргадаггүй;
- Үндсэн чиглэлд тусгасан дэд зорилт, түүнийг хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээ хоёр нь уялдаагүй, тухайн зорилтыг хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээг оновчтой тодорхойлоогүйгээс нэг арга хэмжээний тайлагнал өөр бусад арга хэмжээний тайлагналтай давхардаж тайлагнасан;
- 2021-2025 онд хийгдсэн гэрэлтүүлгийн ажлын талаар тайлагналд тусгаагүй;
- Зохион байгуулсан арга хэмжээний үр дүнг тайлагнадаггүй;
- Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулж байгаа дотоодын цэргийн талаарх мэдээллийг тайлагнаагүй;
- Бодлогын баримт бичгийг заасан хугацаанд тайлагнаагүй, хугацаа хоцроож тайлагнасан;
- “Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулах тусгай цэс байхгүйгээс хэрэгжүүлэгч байгууллагууд өөрийн байгууллагын үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээллийг байгууллагын шилэн дансны цахим хуудаст мэдээлсэн байна. Харин гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийг шилэн дансанд мэдээлээгүй;
- “Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилт, тайлагналыг олон нийтэд ил тод мэдээлээгүй байна.

Энэ нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.7¹⁴, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журмын 4.9.4¹⁵, 5.4¹⁶, 10.8¹⁷, 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан журмын 8.7¹⁸, аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар баталсан журмын 9.6.4¹⁹ дэх заалттай нийцэхгүй байна.

Дээрх алдаа нь бие биедээ тавих зарчимч шаардлага, төрийн албан хаагчдын үүрэг, хариуцлага, тайлагнах байдал шат бүхэнд суларсан нь үр дүнд суурилсан удирдлагын менежмент сулрах эрсдэлд хүргэж байгаад цаашид анхаарч ажиллах нь зүйтэй байна.

Иймд “Баянхонгор аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг хэрэгжилтийг бодитой үнэлэх, санхүүжилтийн мөнгөн дүнг үнэн зөв тайлагнаж байгаад тавих хяналтыг сайжруулах, мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулахыг аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ын даргад зөвлөв.

2.15. Баянхонгор аймгийн ЗДТГ-ын ХШҮХ нь 2026 онд “Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийг өссөн дүнгээр дүгнэж гараагүй тул ТЗУХ-ээс хэрэгжилтийн өссөн дүнгээр нэгтгэж, дүгнэн, аймгийн ИТХ-ын хурлын хуралдаанд 2026 оны 03 дугаар сарын 13-ны өдөр тайлагнасан байна.

Хүснэгт 8. ХШҮХ, ТЗУХ-ын үнэлгээ

2.16. ТЗУХ-аас үндсэн чиглэлийн хугацаа дууссан тул Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан журмын 6.4²⁰ дэх заалтын дагуу 106 арга хэмжээг үнэлж, үүнээс 97 арга хэмжээг “Үр дүн гарсан”, 9 арга хэмжээг “Үр дүнгүй” гэж үнэлснээс 1 арга хэмжээг 0 хувиар, 8 арга хэмжээг 70 хувиар үнэлжээ. (Хавсралт 7)

Эх сурвалж: Эх сурвалж: Баянхонгор аймгийн ЗДТГ-аас ирүүлсэн БАХТЖҮЧ

Үнэлгээ	ХШҮХ	ТЗУХ
100%	65	68
90%	28	29
70%	11	8
50%	1	0
0%	0	1
Үнэлээгүй	1	0
Дүн	106	106

Баянхонгор аймгийн ЗДТГ-аас үнэлгээг зөвхөн гурван түвшинд хязгаарласан нь бодит хэрэгжилтийг нарийвчлан илэрхийлэх боломжийг хязгаарласан байгаад цаашид анхаарч ажиллах нь зүйтэй байна.

2.17. Баянхонгор аймгийн ИТХ-ын 11 дүгээр хуралдаанаар “Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийн явцыг хэлэлцэн тус хуралдааны 11/11 дүгээр тогтоолоор үндсэн чиглэлийн биелэлтийг 94 хувь буюу “Үр дүн гарсан” гэж үнэлсэн байна.

2.18. Дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг аймгийн ИТХ-д тайлагнахдаа Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Үнэлгээ хийх журам”-ын дагуу хийгээгүй, тус тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хяналт-шинжилгээ

¹⁴ 5.2.7. “ил тод, нээлттэй байх зарчим” гэж хуулиар хамгаалагдсан төрийн болон албаны нууцын зэрэглэлтэй мэдээлэл агуулснаас бусад тохиолдолд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг олон нийтэд ил тод мэдээлэх, албан ёсоор хэвлэн нийтлэхийг;

¹⁵ 4.9.4. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх албан хаагч нь дараах үүрэгтэй байна: Тайлан дахь хүрсэн түвшний талаарх мэдээллийн үнэн, зөв эсэхийг нягтлан шалгах;

¹⁶ 5.4. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнахдаа хэрэгжилтийн явц, үр дүнг тухайн тайлант хугацааны болон өссөн дүнгээр тус тус тайлагнана.

¹⁷ 10.8. Цахим сан нь ил тод байдлыг хангах зорилгоор олон нийтэд зориулагдсан нээлттэй хэсэгтэй байна.

¹⁸ 8.7. Нэгдсэн систем нь ил тод байдлыг хангах зорилгоор олон нийтэд зориулагдсан “Хяналтын самбар” хэсэгтэй байна.

¹⁹ 9.6.4. Мэдээллийн цахим сан нь ил тод байдлыг хангах зорилгоор олон нийтэд зориулагдсан хэсэгтэй байна.

²⁰ 6.4. Хэрэгжих хугацаа дууссан бодлогын баримт бичгийн үр дүнг дараах байдлаар дүгнэнэ: бодлогын баримт бичгийн хэрэгжилт нь зорилтот түвшний 85 хувиас дээш бол “үр дүн гарсан”; 2/бодлогын баримт бичгийн хэрэгжилт нь зорилтот түвшний 85 хувьд хүрээгүй бол “үр дүнгүй”

хийх журам"-ын дагуу үнэлсэн ба ингэж үнэлэхдээ журмын 2.1²¹-т заасан хяналт-шинжилгээ хийх зарчмыг баримтлаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр салбарын хэмжээнд гарсан томоохон ажил, арга хэмжээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар тайлагнаагүй, зөвхөн статистикийн тоон үзүүлэлтээр нэгтгэж тайлагнасан;
- "Үр дүнгүй" гэж үнэлсэн 9 арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байсан шалтгааныг дэлгэрэнгүй тайлагнаагүй нь 5.5²² дахь заалттай нийцээгүй;
- Дээрх үр дүнгүй үнэлсэн арга хэмжээнээс "Баянхонгор аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн чиглэл"-д 3.1.4 дэх "Жендэр ба хөгжил хандлагыг төлөвшүүлнэ" заалтыг 4.2.2-т, 7.3.1 дэх "Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоох замаар түүнээс урьдчилан сэргийлэх, гаралтыг бууруулна" заалтыг 4.2.5-т, 8.1.2 дахь "Аймгийн Нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж, нислэгийн тоог нэмэгдүүлэх, нисэх буудлын үйл ажиллагааг олон улсын стандартад хүргэнэ" заалтыг 5.6.1.2-т тусгасан байхад журмын 7.1²³-т заасны дагуу арга хэмжээг цаашид эрчимжүүлж, үр дүн гаргах талаар тодорхой санал, авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж дүгнэж, хэлэлцээгүй;
- Үнэлгээгээр нийт 106 арга хэмжээг үнэлсэн байхад 105 арга хэмжээ дүгнэснээр тайлагнасан (86 дугаарыг давхардуулсан);
- Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд гарсан нийт зардлыг тайлагнаагүй, зөвхөн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн арга хэмжээний зардлыг тайлагнасан²⁴ байна.

Иймд "Баянхонгор аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн хэрэгжилтийг Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд багтаан аймгийн ИТХ-д жил бүр үнэн зөв тайлагнаж байхыг аймгийн ХШҮХ-ын даргад зөвлөв.

2.19. Баянхонгор аймгийн ЗДТГ төлөвлөсөн зорилт, арга хэмжээг хэдэн хувьтай хэрэгжүүлсэнд ач холбогдол өгч байгаагаас "Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д тодорхойлсон зорилго, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлснээр нийгэм, эдийн засагт ямар үр нөлөө бий болж байгааг тооцож үнэлээгүй байна.

2.20. "Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ салбар тус бүрээр гаргасан статистик мэдээнд тулгуурлаж, үнэлсэн ба тус бодлогын баримт бичгийг анх боловсруулахдаа шалгуур үзүүлэлт, зорилтот болон хүрэх түвшнийг тодорхойлоогүй тул аудитаар тулгалт хийж, дүн шинжилгээ хийх боломжгүй байна.

2.21. Баянхонгор аймгийн 2025 оны статистикийн мэдээлэл албажиж гараагүй тул аймгийн нийгэм, эдийн засгийн зарим үзүүлэлтийг 2021, 2024 оноор харьцуулахад "Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д тусгасан зарим арга хэмжээнүүдийн үр дүнд эерэг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 9. Зарим арга хэмжээний суурь, хүрэх түвшин, үр дүнгийн харьцуулалт

Үзүүлэлт	Суурь түвшний үзүүлэлт	2021 он	2025 он
Соёлын биет бус өв	тоо	305	347
Угийн бичиг хөтөлсөн өрхийн / нийт өрхөд эзлэх түвшин/	хувь	14	36
Залуучуудын хөдөлмөр эрхлэлт	хувь	56.6	59.2
Багшийн гүйцэтгэлийн үнэлгээгээр урамшуулал авсан багш /1-3 түвшин/	тоо	-	70
Бага, суурь боловсролын сургалтын амжилтын дундаж	хувь	48.9	58
Сургуулийн үдийн хоолны илчлэг,шим тэжээлийн хангалт	хувь	35	98
Элсэлтийн ерөнхий шалгалтын онооны дундаж	оноо	532	493

²¹ 2.1. Хяналт-шинжилгээг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг тогтмол хугацаанд хэмжих байдлаар дараах зарчмыг баримтлан хийнэ:

²² 5.5. Хэрэгжих хугацаа дууссан боловч "үр дүн гараагүй" бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангалтгүй байсан шалтгааныг нэгдсэн системд дэлгэрэнгүй тайлагнана.

²³ 7.1. Хяналт-шинжилгээний дүнгээр хэрэгжиж байгаа бодлогын баримт бичиг "үр дүн гараагүй" болон "үр дүн хангалтгүй" үнэлэгдсэн тохиолдолд бодлого хэрэгжүүлэгч нь хяналт-шинжилгээний дүгнэлт, зөвлөмжид үндэслэн дараах арга хэмжээнээс аль тохирохыг авч хэрэгжүүлнэ:

²⁴ 3.1.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээ нь шалгуур үзүүлэлт, тоо баримт, судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх

Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл

Засгийн газрын 1111 төвд ирүүлсэн гомдол /эрүүл мэндийн салбар/	тоо	3	19
Үр хөндөлт	тоо	166	104
Хамгааллын үйлчилгээнд хамрагдсан хүүхэд	тоо	274	1683
Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд	тоо	13	27
Ажилгүй иргэд	тоо	5343	2811
Шинээр бий болсон ажлын байр	тоо	406	908
Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрх	тоо	6921	3631
Халамжаас хөдөлмөрт шилжсэн иргэд	тоо	11	66
Тарьсан мод	ширхэг	115,000	798,694
Ойн хортон шавж устгал	га	-	12,300
Эдийн засгийн эргэлтэд оруулсан хог хаягдлын хэмжээ	тн	1,036.5	3,145
Гэмт хэргийн илрүүлэлт	хувь	56.7	58.3
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	428	706

Эх сурвалж: Статистик мэдээ

Шийдвэрлэлт: Дунд хугацааны бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр нийгэм, эдийн засаг, иргэдийн амьдралд гарсан үр нөлөөг бодитой үнэлж, дүн шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

“Баянхонгор аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д хүний хөгжлийн үзүүлэлтийн индекс 0.687-г 0.727, боловсролын индекс 0.58-г 0.635, хөдөлмөр эрхэлж байгаа боловч ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй хүн амын хувийн жин 21.3-г 15.1-д, Инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдардаг өрхийн хувийг 32.8-аас 42-д, ажилгүйдлийн түвшнийг 6.1-ээс 5.2-д хүргэснээр 2030 онд аймгийн өрсөлдөх чадварын үзүүлэлтээр улсад 16-д орсныг 2030 онд 7-д орж 9 байраар урагшлуулах зорилтыг тавьжээ.

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт уул уурхайн салбар эрчимтэйгээр хөгжиж, томоохон хөрөнгө оруулалтууд хийгдэхээр байгаа ба “Баянхонгор аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”- баяжуулах үйлдвэрийн тоог 2-оос 4 болгохоор зааснаас өөрөөр уул уурхайн салбарт хийгдэх хөрөнгө оруулалт, ажлын байр, орлого бүрдүүлэлт, нөхөн сэргээлт, аюулгүй байдлын талаар тусгасан бодлогын баримт бичиг байхгүй байна.

Шийдвэрлэлт: Хувийн хэвшилд түшиглэсэн ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн тэнцвэртэй олон талт бүтцийг бий болгож, үндэсний язгуур эрх ашгийг хамгаалахад чиглэсэн бодлогыг Баянхонгор аймагт боловсруулж, дунд болон урт хугацааны бодлогын баримт бичигт тусган хэрэгжүүлэх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Нийцлийн аудитаар нийт 5 зөрчил илэрсэнд зөрчлийг давтан гаргахгүй байх 5 зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

_____оОо_____

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт уялдуулан боловсруулсан боловч хөрөнгө оруулалтын хөтөлбөр, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хариуцагчийг тодорхойлоогүй төлөвлөсөн нь төлөвлөлтийн зарчимд нийцээгүй байна.
2. “Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийг 2021-2025 онд 86.0 хувьтай хэрэгжүүлж, “Үр дүн гарсан” байна.
3. “Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д хэрэгжүүлэхээр тусгасан 13 арга хэмжээг Баянхонгор аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусаагүй байгаа ба энэ нь нэг талаар төлөвлөлт оновчтой бус нөгөө талаар үндсэн чиглэлд тусгасан арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй байх нөхцөлийг үүсгэсэн байна.
4. Баянхонгор аймгийн ТЗУХ нь арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллагуудын хэрэгжилтийг тайлант хугацаанд зарцуулсан хөрөнгийн дүн, санхүүжилтийн эх үүсвэр, хэрэгжүүлсэн арга хэмжээний бодит гүйцэтгэл, холбогдох нотлох баримтад үндэслэж тайлагнаагүй, хэрэгжилтийг хувиар үнэлээгүй байхад ХШҮХ хянаж үнэлгээ өгсөн байна.
5. Баянхонгор аймгийн ЗДТГ төлөвлөсөн зорилт, арга хэмжээг хэдэн хувьтай хэрэгжүүлсэнд ач холбогдол өгч байгаагаас “Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тодорхойлсон зорилго, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлснээр нийгэм, эдийн засагт ямар үр нөлөө бий болж байгааг тооцож үнэлээгүй, хангалтгүй хэрэгжсэн арга хэмжээнд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.
6. Хувийн хэвшилд түшиглэсэн ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн тэнцвэртэй олон талт бүтцийг бий болгож, үндэсний язгуур эрх ашгийг хамгаалахад чиглэсэн бодлогыг аймгийн хэмжээнд батлаагүй байна.

Баянхонгор аймгийн ИТХ-д толилуулах нь:

1. “Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” дунд хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулахдаа журам, аргачлалд заасны дагуу судалгаа, тооцоо, үнэлгээг иж бүрэн хийж, орон нутгийн иргэдийн саналыг авч, олон нийтээр хэлэлцүүлсэн байдал, шаардагдах санхүүжилт, түүний эх үүсвэр, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшнийг тодорхой, оновчтой, үр дүнг илэрхийлэхүйц, хэмжих боломжтой байдлаар тодорхойлсон байдлыг харгалзах
2. Богино хугацааны бодлогын баримт бичгийг батлахдаа “Баянхонгор аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж болохуйц байдлыг авч үзэх

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Баянхонгор аймгийн Засаг дарга Э.Энхбат танаа

1. “Баянхонгор аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгасан арга хэмжээний зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлт, шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшнийг эргэн нягтлан сайжруулах
2. “Баянхонгор аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх, санхүүжилтийн эх үүсвэр нь бүрэн шийдэгдээгүй асуудалд дүн шинжилгээ хийж, шаардлагатай зохицуулалтын арга хэмжээ авах
3. Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн гүйцэтгэлд нийгэм, эдийн засагт ямар үр нөлөө, эерэг өөрчлөлт бий болсныг үнэлж тооцон Үндэсний статистикийн хорооноос гаргадаг статистикийн өгөгдөлд оруулж, нийтэд ил тод, ойлгомжтой хэлбэрээр байршуулах ажлыг зохион байгуулах
4. Хэрэгжүүлэгч байгууллагуудаас ирүүлсэн тайлан, мэдээ, нотлох баримтад дүн шинжилгээ хийж, эх сурвалжийн найдвартай, нотлогдохуйц, бодитой байдлыг харгалзаж, арга хэмжээнд зарцуулсан санхүүжилтийн гүйцэтгэл, түүний эх үүсвэрийг мөнгөн дүнгээр тайлагнасанд хяналт тавьж, хэрэгжилтийг хувиар бодитой үнэлэх
5. Хувийн хэвшилд түшиглэсэн ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн тэнцвэртэй олон талт бүтцийг бий болгож, үндэсний язгуур эрх ашгийг хамгаалахад чиглэсэн бодлогыг Баянхонгор аймагт боловсруулж, дунд болон урт хугацааны бодлогын баримт бичигт тусган хэрэгжүүлэх